

**Стратегийн удирдлага (Strategic Management)**  
Улс төрийн боловсролын академийн дэргэдэх “Либерал” дээд сургууль  
2006-2007 оны хичээлийн жилийн эхний улирал

**Заах багш: Ч Лхагважав, Ph.D.**

**Хичээлийн өдөр ба цаг:**

**Ганцаарчлан ажиллах цаг:**

---

**Хичээлийн танилцуулга**

Энэ курс үзэх “Стратегийн удирдлага” хичээл нь 2 кредит буюу 48 цагийн агуулгын багтаамжтай. Лекц хичээл 16 цаг, семинар 16 цаг, дадлага хичээл 16 цаг байна. Тухайн мэргэжил эзэмшигчдийн суурь мэдлэг чадвар болон тэдний эзэмшвэл зохих цогц чадамжид тавих шаардлага – хэрэгцээ, мөн бусад суурь хичээлийн агуулгын багтаамж зэргээс хамааруулан 1 кредит, эсвэл 2 кредитээс их агуулгатайгаар зааж болно.

Энэ хичээлээр аливаа менежментийн ерөнхий бөгөөд нийтлэг чиг үүрэг, стратеги менежментийн хувилбарт тодорхойлолтууд болон загвар, байнгын хөгжилд баримжаалсан зохион байгуулалтын стратеги шийдэл, арга хандлагын логик үндэс, чиг хандлагын талаар тулгуур ойлголтыг өгнө.

Энэ хичээлийн агуулгын хүрээнд харьцангуй тогтвортой эрхэм зорилго бүхий аливаа байгууллага, зохион байгуулалтын хөгжиж оршин тогтнох орчны боломж, саад болох аюул заналд хийх задлан шинжилгээ, байгууллагажсан үйлийн чиг үүргийн илэрхийлэл болох эрхэм зорилго, хөгжлийн зорилго, зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратегиудын хувилбарууд болон сонголт, нэгжийн стратеги, чиг үүргийн стратегиуд, байгууллагын судалгаа боловсруулалт болон зах зээл хайлт, хүний нөөцийн болон мэдээллийн тогтолцооны менежмент, стратеги хэрэгжүүлэх арга зам болох байгууллагажилтын бүтэц, түүний хувьсал өөрчлөлт, зохион байгуулалт хэрэгжилтийн орчлын болог явцын үнэлгээ, стратеги хэрэгжүүлэх уламжилт арга болох манлайлал, эрх мэдэл, соёл, стратеги хяналт зэрэг үндсэн ойлголт эзэмших, амьдралд хэрэгжүүлэх баримжаа авах болго.

Суралцагчдын суурь цогц чадамжийн түвшин, нийгмийн хөгжлийн хойшлуулшгүй захиалга хэрэгцээ, тухайн курсын онцлог зэргээс шалтгаалан хичээлийн киррикулимд зарим өөрчлөлт тусгагдаж болно.

**Сургалт явуулах арга зүйн зарчим**

Хичээлийн үндсэн ухагдахуун, ойлголтуудыг лекц яриагаар өгөх хэдий ч интернэтэд суурилсан сургалтын хөгжлийн хандлагаар үзүүлэх материал, слайд, зарим soft program, тухайлбал, power point ашиглана. Хичээлд сургалтын арга зүйн хөгжлийн үндсэн зарчим баримтална. Хичээлийн сэдэв, агуулгын багтаамж, суралцагчдын сонирхлоос хамааралтайгаар асуудал дэвшүүлэн заах, харьцуулах, бүлгээр ажиллах, судлах жишээг хэрэглэх гэх мэт олон аргаас сонголтойгоор хэрэгжүүлнэ..

### **Хичээлийн зорилго**

- Стратеги менежментийн тулгуур ухагдахуун, тэдгээрийн хоорондох логик уялдаа, хэрэглээ
- Орчны шинжилгээний арга хэрэгслийн мөн чанар, жишээ
- Бүрэн чанарын менежментийн зарим элемент болох урьдач үнэлгээ, явцын үнэлгээ, хяналт-шинжилгээ, тайлант тойм үнэлгээ, орчлын нэгдсэн үнэлгээ, стратеги хяналтын зориулалт хэрэглээний тойм
- Гаралтын үр дүн, дам үр дүн, нөлөөт үр дүн, хэрэгцээ-чанарын нийц, тэдгээрийг илрүүлэгч заалтуур-индикаторуудын тухай энгийн баримжаа
- Стратеги төлөвлөгөө, борлуулалтын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, мастер төлөвлөгөө хоорондын логик хамааралын тухай энгийн төсөөлөл

зэрэг сэдвээр тойм агуулга эзэмших, түүнийгээ хэрэглэх барилд суралцах дэвсгэр өгөх, удирдлагын шинжлэх ухаанаар эзэмших цогц чадамжид хувь оруулах

### **Хичээлийн үр дүн**


Хичээлийн төгсгөлд суралцагчид:

- Тасралтгүй үйл явц болох “Стратеги менежмент” хичээлийн суурь ухагдахуун, арга техник, үзэл баримтлалын тухай товч тэмдэглэл, төсөөлөл
  - “Стратеги менежмент”-ийн шинжлэх ухааны зарим тулгуур нэр томъёоны тулгуур дохио
  - “Стратеги менежмент”-ийн шинжлэх ухааны мэргэшил, мэргэжлээр гүнзгийрүүлэн судлах, чадвар эзэмших чиг баримжаа, ашиглах судлах нои хэвлэлийн тойм
  - “Стратеги менежмент”-ийн шинжлэх ухаан нь менежментийн ухааны бүх төрөлтэй уялдах үндэс болох тухай логик дэвсгэрийг мэдрэх
  - Бүх төрлийн төлөвлөгөө хоорондын логик уялдаа холбоог таних барил
  - Стратеги менежмент: “Төлөвлөлт – Хэрэгжүүлэлт – Гүйцэтгэл – Үнэлгээ” гэсэн үйл явцыг шинжлэх, төлөглөх, удирдах, үнэлэх арга техникээс танилцах, хэрэглэх баримжаа
  - Зарим жишээ баримт
- зэрэгтэй болно.

### **Хичээлийн залгамж холбоо**

Менежмент, бүх төрлийн удирдлагын олон хичээлийн агуулгатай шууд холбогдох бөгөөд байнгын үйл ажиллагаа бүхий арга замаар хэрэгжүүлэх цогц үйлийг судлах, шинжлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх суурь мэдлэг эзэмших, логик холбоосыг таних мэдээлэл өгнө.

### **Хичээлийн агуулга**



### Үнэлгээ

Суралцагчдын хичээлийн ирц, оролцоо, сурах хүсэл тэмүүллийг үнэлэн дэмжих болно. Хичээл заах барил, орчинг байнга сайжруулах эрэл хийх үнэлгээнд тулгуурлах, лекц – семинар – дадлага оновчтой хослуулах, мэдлэгээ эзэмших зүй тогтол дагуу багаар ажиллах, судлах жишээн дээр дүн шинжилгээ хийх, даалгавар –сэдэв–асуудал боловсруулан хамгаалах ажлыг хийлгэнэ.


Хичээлийн ирц ба оролцоо	10%
Багаар ажиллах даалгавар	15%
Судлах жишээн дээр ажиллах	15%
Боловсруулах ажил багаар хийж хамгаалах	25%
Явцын шалгалт	15%
Эцсийн шалгалт	20%

Даалгавар тус бүрийн агуулга, гүйцэтгэх аргачлал, үнэлгээний төрлийг хичээлээр тухай бүрт нь тараана.

**“Стратеги менежмент” хичээлээр ашиглах ном, материалын жагсаалт:**

- <http://www.hq.nasa.gov/office/codez/strahand/process.htm>
- Peter Wright, Charles D. Pringle, Mark J. Kroll “Strategic Management”, Allyn and Bacon, 1992, 969p;
- <http://www.businessportalsite.com/strategic-management.html>
- [http://cgi.ebay.com/Strategic-Management-By-Fred-R-David-8th-Edition\\_W0QQitemZ150035485170QQcmdZViewItemQQssPageNameZRSS:B:SRCH:US:101](http://cgi.ebay.com/Strategic-Management-By-Fred-R-David-8th-Edition_W0QQitemZ150035485170QQcmdZViewItemQQssPageNameZRSS:B:SRCH:US:101)

**Strategic Management**



*Item Specifics - Textbooks, Education*

Author:	<b>Fred R. David</b>	Edition:	<b>8</b>
Publisher:	<b>Prentice Hall</b>	Educational Level:	<b>College</b>
ISBN:	<b>0130879037</b>	Publication Year:	<b>2000</b>
Format:	<b>Paperback</b>		
Product Type:	<b>Textbook</b>		
Category:	<b>Business &amp; Economics</b>		

- [http://cgi.ebay.com/Strategic-Management-in-the-Knowledge-Economy-Business\\_W0QQitemZ180028942986QQcmdZViewItemQQssPageNameZRSS:B:SRCH:US:101](http://cgi.ebay.com/Strategic-Management-in-the-Knowledge-Economy-Business_W0QQitemZ180028942986QQcmdZViewItemQQssPageNameZRSS:B:SRCH:US:101) (**Strategic Management in the Knowledge Economy: New Approaches and Business Applications**  
by Marius Leibold Gilbert Probst Michael Gibbert

- **Hardcover:** 353pages
- **Publisher:** Wiley-VCH
- **Language:** English
- **ISBN:** 3895782572)

- <http://www.csuchico.edu/mgmt/strategy/module1/>